

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРАЛ
Ч.БАТ-ЭРДЭНЭ

БАТЛАВ:

“АРВАЙ БАРХАН” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ *Н.Сүрэнхорлоо*
Н.СҮРЭНХОРЛОО

“МОНГОЛ УЛСЫН ЭМИЙН БҮРТГЭЛД БҮРТГЭГДСЭН
ЭМИЙН ЖАГСААЛТ” НОМ ХЭВЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2016 оны 3. сарын 17. өдөр

№

Уланбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээг нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид захиалагч гэх-/ийг төлөөлж Эмийн зохицуулалтын албаны дарга Д.Бямбадорж, нөгөө талаас “Арвай бархан” ХХК /цаашид гүйцэтгэгч гэх-/ийг төлөөлж эдийн засагч С.Ариунцэцэг нар дор дурьдсан нөхцлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн захиалга, зааварчилгааны дагуу Монгол улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийн жагсаалт болон биологийн идэвхт бүтээгдэхүүний жагсаалтын 2 төрлийн эмхэтгэлийг хэвлэх, эмхэтгэл хэвлэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

2.2 Эмхэтгэлийн үзүүлэлт:

№	Эмхэтгэлийн нэр	Үзүүлэлт	Toо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	“Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эмийн жагсаалт”	Хэмжээ: А4 /280 нүүрэнд багтана/ Хэвлэх өнгө, цаас материал: Хавтас 4+0 өнгөөр 250 гр шохойтой цаас, бүрэлттэй Дотор 1+1 өнгөөр 100 гр матт цаас	500 ширхэг	7450 төг	3.725.000 төг
2	“Монгол улсын бүртгэлд бүртгэгдсэн биологийн идэвхт бүтээгдэхүүний жагсаалт”	Хэмжээ: А4 /70 нүүрэнд багтана/ Хэвлэх өнгө, цаас материал: Хавтас 4+0 өнгөөр 250 гр шохойтой цаас, бүрэлттэй Дотор 1+1 өнгөөр 100 гр матт цаас	500 ширхэг	2900 төг	1.450.000 төг
					5.175.00 төг

2.3 Гүйцэтгэгч нь хэвлэлийн материалыг номын эхэд оруулж өрсний дараа ном тус бүрийн хуудасны тоог нарийвчлан гаргаж Захиалагчийн хамтаар ажлын хөлсийг эцэслэн тооцох ба энэхүү гэрээнд хавсаргасан “Арвай бархан” ХХК-ний үнийн саналын жишгийг баримтална.

Гурав. Гэрээний хугацаа

- 3.1 Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж 2 төрлийн номыг гэрээнд заасан тоо ширхгийн дагуу эцсийн байдлаар хүлээн авсан зарлагын баримтад Захиалагч гарын үсэг зурснаар дуусгавар болно.
- 3.2 Гэрээний хугацаа нь 2016 оны 03-р сарын 17-ны өдрөөс 2016 оны 03-р сарын 31-ны өдрийг дуустал хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 3.3 Захиалагчийн эрх бүхий этгээд хэвлэлийн эхний хувилбарт хийгдсэн засварыг хянаж баталгаажуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор эмхэтгэлийг хэвлэнэ.

Дөрөв. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

- 4.1 Талууд харилцан тохиролцсоны дагуу “Арвай бархан” ХХК-ийн 2016 оны 03 сарын 16-ны өдрийн үнийн саналыг баримтлан 2 төрлийн нийт 1000 ширхэг номыг урьдчилсан байдлаар нийт 5.175.000 /таван сая нэг зуун далан таван мянга/ төгрөгөөр хэвлэх зардлын 50 % буюу 2.587.500 /хоёр сая таван зуун наян долоон мянга таван зуун/ төгрөгийг урьдчилгаа болгон Гүйцэтгэгчийн Голомт банкин дахь 1165004479 тоот дансанд шилжүүлнэ.
- 4.2 Номын эх бэлэн болсны дараа ажлын хэлсийг эцэслэн тооцох ба Захиалагч нь бүтээгдэхүүн хүлээн авахдаа үлдэгдэл төлбөрийг гүйцэтгэгчийн Голомт банкин дахь 1165004479 тоот дансанд шилжүүлнэ.

Тав. Захиалагчийн эрх, үүрэг

- 5.1 Хэвлэмэл бүтээгдэхүүний файлаа хэвлэлтэд оруулахаас өмнө гүйцэтгэгчийн гаргасан хар болон өнгөт пробыг сайтар хянан гарын үсгээр баталгаажуулна. Засварыг Факс болон и-мэйлээр явуулж болно.
- 5.2 Гүйцэтгэгчийн ажлын явцын талаарх мэдээллийг авах, зааварчилга өгөх, хяналт тавих эрхтэй.
- 5.3 Захиалсан бүтээгдэхүүний тоо хэмжээ дутсан, хэвлэлийн чанарын шаардлагыг хангагүй тохиолдолд гүйцэтгэгчид мэдэгдэж засварлуулсаны дараа хүлээн авах эрхтэй.
- 5.4 Гэрээт ажлын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд барагдуулах үүрэгтэй.
- 5.5 Пробын алдаа магадлалыг дутуу хянаснаас үүссэн дүрмийн болон агуулгын алдааг бүрэн хариуцна.

Зургаа. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 6.1 Хэвлэлийн эхэд өнгөт болон хар проб гаргаж Захиалагчаар хянуулан баталгаажуулна. Засварыг цаас, факс, и-мэйлээр хүлээн авч болно
- 6.2 Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр хэвлэлтийн эхийг өөрчлөхгүй.
- 6.3 Хэвлэлтийн технологоос шалтгаалан хэвлэлийн эхийг зайлшгүй өөрчлөх шаардлагатай бол Захиалагчтай зөвшилцэнэ.
- 6.4 Хэвлэлийн эхэд зөвшөөрөлгүй өөрчлөлт оруулсан, Захиалагчийн хянасан пробын алдааг дутуу засварласан, хэвлэлийн өнгө зөрсөн, хэвлэсэн эмхэтгэл чанарын шаардлага хангахгүй тохиолдолд алдаа доголдлыг арилган өөрийн зардлаар эмхэтгэлийг ажлын 3-5 хоногийн дотор дахин хэвлэн Захиалагчид хүлээлгэн өгнө.

6.5 Захиалагчийн хүлээлгэн өгсөн материалын нууцлалыг бусдад задруулах, номуудыг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гэрээнд зааснаас илүү тоогоор хэвлэх, Захиалагчаас бусад этгээдэд өгөх, зарлан борлуулахыг хориглоно.

Долоо. Хариуцлага

- 7.1 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь гүйцэтгэлийн тодорхой хугацаа зааж бичгээр шаардлага тавих ба уг шаардлагыг биелүүлээгүйгээс үүдэн гарах хохирлыг буруутай тал хариуцна.
- 7.2 Гүйцэтгэгч захиалгыг цаг хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,2%-тай тэнцэх алданги төлнө.
- 7.3 Талууд өөрийн буруутай үйлдлээс нөгөө талд хохирол учруулсан, нэмэлт ажил ба зардал гарсан тохиолдолд учруулсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцах үүрэгтэй.

Найм. Давагдашгүй хүчин зүйл

8.1 Давагдашгүй хүчин зүйл /гал түймэр, газар хөдлөлт, террорист үйлдэл, ажил хаялт г.м./-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлдлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

Ес. Бусад


9.1 Гэрээтэй холбогдон гарсан аливаа маргаан, үл ойлголцох байдлыг талууд харилцан тохиролцох, хүндэтгэлтэй байх зарчмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй нөхцөлд шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

9.2 Энэхүү гэрээг 2% үйлдэн гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болгох бөгөөд талуудад тус бүр нэг хувь хадгалагдана.

9.3 Гэрээний аль нэг талын удирдлага, үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орсон ч энэхүү гэрээ хүчин төгөлдөр хэвээр байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧ:

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
эмийн зохицуулалтын албаны
дарга
 Д.Бямбадорж

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Энхтайвны гудамж-13Б,
Улаанбаатар 210648, Ш/Х-187
Утас: 99164842

ГҮЙЦЭТГЭГЧ:

“Арвай бархан” ХХК
Нягтлан бодогч
 С.Ариунцэцэг

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо
Сүхбаатарын гудамж
Утас/Факс: 11-328422, 99119351